

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4. Менежментийн захидал	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.БОЛОРЧУЛУУН ТАНАА

2021.02.25 № 07/505
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 30-ний өдрөөр тасалбар болсон дуусгалтын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 30-ний өдрөөр тасалбар болсон дуусгалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 64 ажил төлөвлөж хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>148 902 320,75</u>	<u>-</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10 000,00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	10 000,00	-
31110	Төгрөг	10 000,00	-
33	АВЛАГА	75 075 548,00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	75 075 548,00	-
34	УРЬДЧИЛГАА	2 200 000,00	-
34600	Урьдчилж гарсан зардал	2 200 000,00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	71 616 772,75	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	57 367 750,00	-
354	Хангамжийн материал	14 249 022,75	-
35410	Бичиг хэргийн материал	311 500,00	-
35420	Аж ахуйн материал	13 852 522,75	-
35440	Түлш, шатах тослох материал	85 000,00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>500 384 111,76</u>	<u>-</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	500 384 111,76	-
392	Биет хөрөнгө	462 717 445,16	-
39201	Барилга, байгууламж, орон сууц	377 069 836,00	-
39202	Хуримтлагдсан элэгдэл	(41 099 728,16)	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	141 080 900,00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(124 844 762,44)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	142 822 737,93	-
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48 059 770,88)	-
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48 204 261,62	-
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32 456 028,91)	-
393	Биет бус хөрөнгө	37 666 666,60	-
39301	Програм хангамж	2 500 000,00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(666 666,71)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	36 600 000,00	-
39304	Хуримтлагдсан элэгдэл	(766 666,69)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>649 286 432,51</u>	<u>-</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>32 307 672,43</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32 307 672,43	-
413	Өглөг	32 307 672,43	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	520 595,24	-
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	31 787 077,19	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>616 978 760,08</u>	<u>-</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	616 978 760,08	-

Хөдөө аж ахуйн үйлдэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 140 849 243,29	
51101	Өмч: - төрийн	1 108 849 243,29	
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	32 000 000,00	
512	Хуримтлагдсан үр дүн	(523 870 483,21)	
51210	Өмнөх үеийн үр дүн	(523 870 483,21)	
51220	Тайлант үеийн үр дүн	-	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>649 286 432,51</u>	<u>-</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	667 907 100,42	506 359 916,20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7 523 005,42	1 470 616,20
120	Нийтлэг татварын бус орлого	7 523 005,42	1 470 616,20
120002	Хүүгийн орлого	87 038,86	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7 435 966,56	950 017,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	866 522,00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6 569 444,56	950 017,00
120009	Бусад орлого		520 599,20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	660 384 095,00	504 889 300,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275 868 400,00	338 217 700,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	275 868 400,00	338 217 700,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	384 515 695,00	166 671 600,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	165 567 295,00	160 000 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	218 948 400,00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6 671 600,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	580 534 998,06	651 514 666,04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	580 534 998,06	651 514 666,04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	577 525 602,88	570 404 448,97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182 870 295,10	160 029 454,00
210101	Үндсэн цалин	145 436 099,78	115 406 084,00
210102	Нэмэгдэл	13 294 055,82	28 431 370,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15 366 000,00	16 192 000,00
210104	Урамшуулал	2 423 746,55	
210105	Гэрээт ажлын хөлс	6 350 392,95	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22 432 871,91	19 514 184,00
210201	Тэтгэврийн даатгал	17 819 219,37	13 602 506,00
210202	Тэтгэмжийн даатгал	1 168 592,16	1 600 294,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	518 815,19	1 280 235,00
210204	Ажилгүйдлийн даатгал	649 775,48	275 560,00
210205	Эрүүл мэндийн даатгал	2 276 469,71	2 755 589,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14 591 979,00	3 130 827,70
210301	Гэрэл, цахилгаан	1 418 869,00	1 184 327,70
210302	Түлш, халаалт	12 867 852,00	1 946 500,00
210303	Цэвэр, бохир ус	305 258,00	
2104	Хангамж, бараа материалын зардал	11 605 889,00	7 325 318,43
210401	Бичиг хэрэг	1 825 650,00	1 410 300,00

Хөдөө аж ахуйн үйлдэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТУГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	5 408 467,00	3 239 450,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 126 412,00	2 308 118,43
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	55 950,00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	448 110,00	367 450,00
210408	Бараа материал акталсны зардал	1 741 300,00	
2105	Нормативт зардал	100 000,00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100 000,00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13 450 700,00	2 945 199,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	116 200,00
210604	Урсгал засвар	13 450 700,00	2 828 999,00
2107	Томиллолт, зочны зардал	3 865 733,48	2 819 600,00
210702	Дотоод албан томиллолт	3 865 733,48	2 819 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	240 081 103,05	171 960 354,46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	236 829 501,01	169 402 422,46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 500 000,00	1 500 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	576 298,00	71 280,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287 000,00	357 452,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	83 000,00	45 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	614 500,00	574 200,00
210807	Газрын төлбөр	128 800,00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	62 004,04	10 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88 527 031,34	202 679 511,38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-147 742 018,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5 053 400,00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83 473 631,34	54 937 493,38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3 009 395,18	81 110 217,07
2132	Бусад урсгал шилжүүлэг	500 000,00	36 549 900,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	35 849 900,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500 000,00	700 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2 509 395,18	44 560 317,07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2 509 395,18	44 560 317,07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	87 372 102,36	(145 154 749,84)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	589 877 803,31	483 358 861,13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	589 877 803,31	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	483 358 861,13
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(589 877 803,31)	(483 358 861,13)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(502 505 700,95)	(628 513 610,97)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>643 087 912,86</u>	<u>579 964 848,00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	148 271 112,86	75 075 548,00
120	Нийтлэг татварын бус орлого	148 271 112,86	75 075 548,00
120002	Хүүгийн орлого	87 038,86	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	138 114 188,00	75 075 548,00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	75 075 548,00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	138 114 188,00	
120009	Бусад орлого	10 069 886,00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	494 816 800,00	504 889 300,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275 868 400,00	338 217 700,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	275 868 400,00	338 217 700,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	218 948 400,00	166 671 600,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	160 000 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	218 948 400,00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6 671 600,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>650 590 641,77</u>	<u>574 392 078,00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	650 590 641,77	574 392 078,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	647 581 246,59	493 981 860,93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161 692 506,30	-
210101	Үндсэн цалин	143 118 378,88	
210102	Нэмэгдэл	10 476 737,88	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5 550 000,00	
210104	Урамшуулал	1 226 651,40	
210105	Гэрээт ажлын хөлс	1 320 738,14	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42 810 430,77	-
210201	Тэтгэврийн даатгал	24 878 881,39	
210202	Тэтгэмжийн даатгал	3 243 575,00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 082 012,00	
210204	Ажилгүйдлийн даатгал	2 655 000,00	
210205	Эрүүл мэндийн даатгал	10 950 962,38	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14 591 979,00	3 011 654,00
210301	Гэрэл, цахилгаан	1 418 869,00	1 065 154,00
210302	Түлш, халаалт	12 867 852,00	1 946 500,00
210303	Цэвэр, бохир ус	305 258,00	
2104	Хангамж, бараа материалын зардал	11 383 589,00	6 714 393,43
210401	Бичиг хэрэг	2 109 650,00	1 036 500,00

Хөдөө аж ахуйн үйлдэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТУГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	5 433 467,00	3 126 075,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 126 412,00	2 308 118,43
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	55 950,00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	475 610,00	243 700,00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1 182 500,00	
2105	Нормативт зардал	100 000,00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100 000,00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13 705 600,00	3 125 599,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	74 900,00	296 600,00
210604	Урсгал засвар	13 630 700,00	2 828 999,00
2107	Томилолт, зочны зардал	3 874 333,48	2 412 600,00
210702	Дотоод албан томилолт	3 874 333,48	2 412 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	394 018 408,04	361 969 046,50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	387 262 906,00	359 421 114,50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 500 000,00	1 500 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	576 298,00	71 280,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287 000,00	357 452,00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	83 000,00	45 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4 118 400,00	574 200,00
210807	Газрын төлбөр	128 800,00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	62 004,04	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5 404 400,00	116 748 568,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	116 748 568,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5 404 400,00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3 009 395,18	80 410 217,07
2132	Бусад урсгал шилжүүлэг	500 000,00	35 849 900,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	35 849 900,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500 000,00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2 509 395,18	44 560 317,07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2 509 395,18	44 560 317,07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(7 502 728,91)</u>	<u>5 572 770,00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	5 582 770,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5 582 770,00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5 582 770,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5 582 770,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-</u>	<u>(5 582 770,00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(7 502 728,91)	(10 000,00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7 512 728,91	10 000,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10 000,00	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Эздийн өмчийн бусад хэсэг	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 108 849 243,29	(21 364 782,26)	32 000 000	1 119 484 461,03
Тайлант үеийн үр дүн	-	(502 505 700,95)	-	(502 505 700,95)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 108 849 243,29	(523 870 483,21)	32 000 000	616 978 760,08
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	11 534 850,89	-	11 534 850,89
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 108 849 243,29	(512 335 632,32)	32 000 000	628 513 610,97
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	1 108 849 243,29	(1 140 849 243,29)	(32 000 000)	-
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	338 217 700,00	293,668,382.93	44 549 317,07	100,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	338 217 700,00	338 227 700,00	44 549 317,07	100,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302 367 800,00	257 818 482,93	44 549 317,07	85,27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6 714 400,00	3 011 654,00	3 702 746,00	
210301	Гэрэл, цахилгаан	2 112 300,00	1 065 154,00	1 047 146,00	50,43
210302	Түлш, халаалт	4 201 100,00	1 946 500,00	2 254 600,00	46,33
210303	Цэвэр, бохир ус	401 000,00	-	401 000,00	0,00
2104	Хангамж, бараа материалын зардал	8 163 300,00	6 714 393,43	1 448 906,57	
210401	Бичиг хэрэг	1 126 400,00	1 036 500,00	89 900,00	92,02
210402	Тээвэр, шатахуун	4 200 800,00	3 126 075,00	1 074 725,00	74,42
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 637 300,00	2 308 118,43	329 181,57	87,52
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	198 800,00	243 700,00	(44 900,00)	122,59
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3 368 600,00	3 125 599,00	243 001,00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	538 600,00	296 600,00	242 000,00	55,07
210604	Урсгал засвар	2 830 000,00	2 828 999,00	1 001,00	99,96
2107	Томилолт, зочны зардал	2 835 000,00	2 412 600,00	422 400,00	
210702	Дотоод албан томилолт	2 835 000,00	2 412 600,00	422 400,00	85,10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	280 036 400,00	242 554 236,50	37 482 163,50	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	276 352 500,00	240 006 304,50	36 346 195,50	86,85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 500 000,00	1 500 000,00	-	100,00
210803	Даатгалын үйлчилгээ	826 500,00	71 280,00	755 220,00	8,62
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450 000,00	357 452,00	92 548,00	79,43
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66 000,00	45 000,00	21 000,00	68,18

Хөдөө аж ахуйн үйлдэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	746 000,00	574 200,00	171 800,00	76,97
210807	Газрын төлбөр	95 400,00	-	95 400,00	0,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 250 100,00	-	1 250 100,00	0,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 250 100,00	-	1 250 100,00	0,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35 849 900,00	35 849 900,00	-	0,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35 849 900,00	35 849 900,00	-	0,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35 849 900,00	35 849 900,00	-	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	338 217 700,00	338 217 700,00	-	0,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	338 217 700,00	338 217 700,00	-	0,00
122005	Орон нутгийн төсвөөс	338 217 700,00	338 217 700,00		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10 000,00	-	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	15	16	-	0,0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	13		
650010	Гэрээт ажилтан		3		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		241 746 148,00
УРСГАЛ ЗАРДАЛ		241 746 148,00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		241 746 148,00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		124 997 580,00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		124 997 580,00
Бараа үйлчилгээний бусад зардал		116 748 568,00
Бараа үйлчилгээний бусад зардал		116 748 568,00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1 000,00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1 000,00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		166 671 600,00
Нэмэлт санхүүжилтийн орлого		166 671 600,00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		160 000 000,00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		6 671 600,00
Татаас, санхүүжилтийн авлага		75 075 548,00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 30-аар тасалбар болсон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ХХААХҮЯ-ны ажлын хэсгийн ахлах Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийг үр дүнтэй зарцуулж байх, бараа материалын тайланг стандартын дагуу гаргаж байх, шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, туслах аудитор Б.Оюунцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх нь төв УТҮГ нь 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон хаалтын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт болон Пийк ОМ Аудит ХХК-д 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх нь төв УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэг сургалт явуулах
- Мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Загийн Газрын 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 93 тоот тогтоолоор бүтцийн өөрчлөлт татан буугдсан байна

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх нь төв УТҮГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн Яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх нь төв УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 294,482. мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,944.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болсон хаалтын Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 651,514.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,515.1 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тооцсон.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх нь төв УТҮГ-ын 2020 оны 9 дүгээр сарын 30-аар тасалбар болсон хаалтын санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 160,729.8 мянган төгрөгөөр буюу 24.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	2020.09.30 хаалтын үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10.0		-10.0
Татаас санхүүжилтийн авлага	75,075.5		-75,075.5
Урьдчилж гарсан зардал	2,200.0		-2,200.0
Бараа материал	71,616.8		-71,616.8
Үндсэн хөрөнгө	500,384.1		-500,384.1
Нийт хөрөнгө	649,286.4		-649,286.4
Өр төлбөр	32,307.7		-32,307.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	616,978.7		-616,978.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	649,286.4		649,286.4

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 8,950.5 мянган төгрөгөөр буюу 13.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого нь цаг тооны бичгийн борлуулалтын орлого байна.

Нийт зардал өмнөх оны 9 сарын 30-ний байдлаас 36,704.1 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 36,704.1 мянган төгрөгийн зардал нь төслийн үйл ажиллагаатай холбоотой гарсан зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр ба нийт зарлагыг 428,073.4 мянган төгрөгөөр, тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 79,847.6 мянган төгрөгөөр бууруулж 428,072.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 428,072.4 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2020 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 338,227.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 293,668.4 мянган төгрөгийг зарцуулж 44,559.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 293,668.4 мянган төгрөг буюу 86.8 хувьтай байгаа нь, Засгийн газрын тогтоолоор тус газрын татан буулгаж үйл ажиллагааг нь зогсоосонтой холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Швейцарийн хөгжлийн агентлагаас 160,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,671.9 мянга, нийт 166,671.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 160,000.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 6,670.9 мянга, нийт 166,670.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 134 мэдээллийг хугацаанд нь 11 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан бол, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15,794.4 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24,522.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 24,522.7 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, 319.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 1,378.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байсныг залруулга хийлгэсэн.
2. Бараа материалын дансанд бүртгэлтэй 21,800.0 мянган төгрөгийн малчдын цаг тооны бичгийг анхан шатны баримтгүйгээр тайлант оны зардлаар бүртгэснийг авлагаар бүртгэж залруулга хийлгэсэн.
3. Бараа материалын дансанд бүртгээгүй, тооцооны дансаар дамжуулаагүй мөн биетээр байгаа бараа материалыг санхүүгийн тайланд зардлаар тайлагнасан 1,016.8 мянган төгрөгийг алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа , зөрчил илрээгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 319.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 93 тоот тогтоолоор тус газрыг татан буулгасан байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Нягтлан бодогчид үр дүнгийн урамшуулал давхардуулан 319.0 мянган төгрөгөөр илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Эрсдэл: Холбогдох хууль, журам зааврыг мөрдөж ажиллаагүй байх;
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах;
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Бараа материалын тайланг стандартын дагуу бэлтгээгүй, хөрөнгийг бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2.2. Эрсдэл: Тайлант хугацааны үр дүн буруу илэрхийлэгдэх, холбогдох стандарт, заавар, журмыг мөрдөж ажиллаагүй байх;
- 2.3. Өгсөн зөвлөмж: Цаашид Бараа материалын дансаар дамжуулан бүртгэж, бараа материалын тайланг стандартын дагуу гаргаж байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах;
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3. Шилэн данстай холбоотой асуудал

- 3.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд мэдээллээ хугацаанд нь байршуулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацааны 31 мэдээллийг хугацаа хоцроон шилэн дансны цахим хуудсанд байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай нийцэхгүй байна.
- 3.2. Эрсдэл: Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байх;

3.3. Өгсөн зөвлөмж: Шилэн данстай холбоотой мэдээллийг тогтоосон цаг хугацаанд нь мэдээлж байх, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын нэр: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/315./СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Мянган төгрөг	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв УТҮГ	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нягтлан бодогчид үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон байна.	319.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Я.Болдбаатар
2	Бараа материалын тайланг стандартын дагуу бэлтгээгүй, бараа материалын дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэж байна.		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Я.Болдбаатар
ДҮН		319.0			

